



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/20

Номгон

Баянхонгор аймгийн 2021 оны нэгдүгээр
ээлжийн цэргийн жинхэнэ албаны цэрэг халалт,
татлагын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны мн/203 дугаар тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2021 оны н/51 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд цэргийн жинхэнэ албаны хугацаа дуусч бэлтгэлээр халагдсан байлдагч, түрүүчийг хүлээн авах, цэргийн жинхэнэ албанд иргэдийг татах, цэргийн гэрээт албанд элсүүлэх ажлыг 2021 оны 04 дүгээр сарын 18-аас 28-ны өдрүүдэд зохион байгуулж явуулсугай.

2. Цэрэг татлагын товчооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр, цэрэг татлага явуулах хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Цэрэг татлагын товчоонд даалгах нь:

а/ Цэрэг татлагын товчооны гишүүд, ажиллагсдын ажил үүргийн хуваарийг тогтоон, цэрэг татлагын ажилтай холбоотой хууль, эрх зүйн баримт, тухайн ажлыг гүйцэтгэх онцлогийн талаар зааварчилгаа өгч, бусад зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах.

б/ Цэргийн жинхэнэ албаны татлагын ажлыг сайн зохион байгуулан явуулж Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 11 дүгээр тогтоол "Цэргийн гэрээт алба хаах журам"-ийн дагуу иргэнийг цэргийн гэрээт албанд элсүүлэх, "Журам батлах тухай" 2017 оны 144 дүгээр тогтоолоор батлагдсан "Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам"-ыг баримтлан иргэдийг цэргийн жинхэнэ албанд тэнцүүлэн татаж Зэвсэгт хүчний Жанжин штабаас өгсөн тоон даалгаврыг биелүүлэх.

621010601

в/ Монгол Улсын Цэргийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйл, 13 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлж цэргийн гэрээт албанд элсүүлэх, цэрэг халалт, татлагын ажлын явцад байнгын хяналт тавьж, цэрэг татлагын товчооны үйл ажиллагаатай холбогдуулан иргэдээс гаргасан санал хүсэлт, өргөдөл гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх.

г/ Цэрэг татлагын ажлын дүн, мэдээг 2021 оны 05 дугаар сарын 10-ны дотор Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабт өгөх.

4.Цэрэгт татагдагчдыг коронавирус (covid-19)-ээс урьдчилан сэргийлэх, халдвар хамгаалалтыг дэглэмийг сахиулах бүх талын арга хэмжээ авч цэрэг татлагын байрыг ариутгуулах, эрүүл мэндийн үзлэг явуулах нарийн мэргэжлийн эмч, сувилагч нарыг томилон холбогдох зааварчилгааг өгч мэргэжлийн удирдлага, шаардлагатай байр, эм эмнэлгийн багаж төхөөрөмжөөр хангаж, төрийн үйлчилгээг үзүүлэх;

а.Зарлан дуудах мэдэгдэл авсан цэргийн албанд татагдагч, цэргийн жинхэнэ албаны хугацаагаа дуусан бэлтгэлээр халагдаж ирсэн түрүүч, байлдагч нарын халууныг үзэж, ариутгал халдваргүйжүүлэлтийг хийх;

б.Сумдад татлагаар сүрьеэгийн эрт илрүүлэгийг хийж, сүрьеэгээр өвчилж болзошгүй болон сүрьеэгийн ойрын хавьталттай, халдвар авсан, суурь өвчтэй иргэдийн судалгаа гаргах, цэргийн жинхэнэ албанд тэнцсэн иргэдээс түргэвчилсэн оношлуураар тестээр авч ажиллахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал), Нэгдсэн эмнэлэг (Ч.Жавзан)-т нарт даалгасугай.

5.Гэмт хэргийн холбогдолтой болон хэрэг нь шүүхээр шийдвэрлэгдээгүй хүлээгдэж байгаа иргэдийн судалгааг гаргах, коронавирус (covid-1)-ээс урьдчилан сэргийлж цэрэг татлагын байрны орчим ар гэрийнхэн болон гадны иргэдийг олноор цуглуулахгүй байх, цэрэг халалт, татлагын үед нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, зарлан дуудах мэдэгдэл аваад тогтоосон хугацаанд цэрэг татлагын байранд ирээгүй цэргийн үүрэгтнийг эрэн сурвалжилж татлагаар оруулах бүх талын арга хэмжээ авахыг Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Оюутболд)-т даалгасугай.

6.Цэрэгт татагдагчдыг тээвэрлэх автомашины техникийн бүрэн бүтэн байдлыг хангуулж зөвшөөрөл өгөх, жолооч нарын хариуцлагыг дээшлүүлж хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч ажиллахыг сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг (цагдаагийн хошууч А.Батхуяг)-т даалгасугай.

7. Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулинд заагдсан орон нутгийн төрийн захиргааны албан тушаалтан, байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригчид, иргэдийн хүлээх үүрэг хариуцлага, Засгийн газрын “Журам батлах тухай” 2018 оны 11 дүгээр тогтоол “Цэргийн гэрээт алба хаах журам”, 2018 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журам”-ын талаар сурталчилгааны ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр сурталчлах, түүнд иргэдийг элсүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Цэргийн штаб (хурандаа Г.Нэмэхбаяр)-т даалгасугай.

8. Сумдын Засаг дарга нарт даалгах нь:

а/ Цэрэг татлагын ажлыг явуулах “Цэрэг татлагын товчоо”-г захирамжаар баталгаажуулан сумын Засаг даргын Тамгын газрын даргаар ахлуулж, товчооны бүрэлдэхүүнд нутгийн захиргааны байгууллагын албан хаагч болон шаардлагатай мэргэжлийн байгууллагын ажилтныг томилон гүйцэтгэх ажил үүргийг тодотгон зааварчилгаа өгч, ажиллах байр, тээврийн хэрэгслэлээр хангаж, шаардагдах төсөв хөрөнгийг хуульд нийцүүлэн гаргаж ажиллах.

б/ Сумын цэрэгт татагдах 18-25 (1996-2003 он) залуучуудад нэрийн бүртгэлийн дагуу цэргийн жинхэнэ албаны зарлан дуудах мэдэгдлийг нэг бүрчлэн гардуулж, тооцоог тасалбараар Цэргийн штабтай хийх.

в/ Цэргийн насны залуучуудыг цэрэг татлагын товчоогоор бүрэн хамруулах арга хэмжээ авч ажиллах.

г/ Коронавирус /сovid-19/-ын халдвараас сэргийлж цэрэг татлага явагдах байрыг ариутгуулж, байранд зөвхөн захирамжаар томилогдсон цэрэг татлагын товчоо, цэргийн насны залуучуудыг амны хаалт зүүлгүүлж, халууныг үзэж, гарыг ариутгуулж оруулах, ар гэрийнхэн болон гадны иргэдийг цэрэг татлагын байранд нэвтрүүлэхгүй байх цэргийн насны залуучуудыг нэг доор олноор цуглуулахгүй байх арга хэмжээг авч ажиллах.

д/ Цэргийн насны залуучуудыг татлагаар орохоос өмнө шинжилгээнд бүрэн хамруулсан байх.

е/ Цэрэг татлагын товчоогоор ороогүй цэргийн үүрэгтэнг эрэн сурвалжилж шалтгааныг тодотгон хүн тус бүрийн нэрээр тооцоог гаргаж Цэргийн штабтай хийх.


ё/ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль болохтой холбогдуулан Цахим үнэмлэхтэй иргэдийг цэргийн жинхэнэ албанд тэнцүүлэн татах.

9. Цэргийн жинхэнэ албаны татлагаар зарлан дуудах мэдэгдэл авсан иргэн тогтоосон өдөр, цагт цэрэг татлагын байр, товлосон газарт хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол Монгол Улсын Цэргийн албаны тухай хуулийн 36


дугаар зүйлийн 36.2, Зөрчлийн тухай хуулийн 15.17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу арга хэмжээ ажиллахыг Цэргийн штаб /хурандаа Г.Нэмэхбаяр/-т үүрэг болгосугай.

10.Цэрэг татлагын зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /М.Өнөржаргал/-д зөвшөөрсүгэй.

11.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр
сарын 05-ны өдрийн А/240 дүгээр захирамжийн
1 дүгээр хэвсрагт



ЦЭРЭГ ТАТЛАГЫН ТОВЧООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга: М.Өнөржаргал -Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Орлогч дарга: Г.Нэмэхбаяр – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа

Нарийн бичгийн дарга: Т.Мөнхбат - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер, хошууч

Гишүүдэд: Г.Болдбаатар - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дайчилгааны офицер, ахмад

Г.Бат-Өлзий - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер, ахмад

Б.Оюутболд - Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа

Н.Энхжаргал - Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Ц.Энхтөр – Боловсрол, соёл урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Д.Мөнхбат - Нийгмийн даатгалын хэлтсийн дарга

Ц.Мөнхжаргал – Улсын бүртгэлийн хэлтсийн дарга


Ч.Жавзан - Нэгдсэн эмнэлгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
/ерөнхий эмч/

С.Эрдэнэчулуун – Дотор, халдвартын их эмч

С.Энхбаяр – Чих, хамар хоолойн их эмч

Н.Одонтуяа – Арьс харшилын их эмч

Аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр
сарын 05-ны өдрийн А/240 дүгээр захирамжийн
2 дугаар хавсралт



ЦЭРЭГ ТАТЛАГА ЯВУУЛАХ ХУВААРЬ

д/д	Сумдын нэрс	Хуваарь	
		Өдөр	Цаг
1	Баянхонгор	18/IV	10.00
2	Баянхонгор	19/IV	10.00
3	Эрдэнэцогт	20/IV	10.00
4	Жинст	21/IV	10.00
5	Богд	22/IV	10.00
6	Баянлиг	23/IV	10.00
7	Баянговь	24/IV	10.00
8	Шинэжинст	25/IV	10.00
9	Баян-Өндөр	26/IV	10.00
10	Баянцагаан	27/IV	10.00
11	Баацагаан	28/IV	10.00

оОо